



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/237

Улаанбаатар хот

Худалдан авах ажиллагааны
төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалт, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг өөрчлөн баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөний хүрээнд худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулан ажиллахыг Үнэлгээний хорооны дарга, нарийн бичиг, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (П.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/73 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



П.АЛТАНЦЭЦЭГ

Батлав

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

№	Тендер шалгаруулагчтын код	Худалдан авах бараа, ажил үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр, нэр, төрөл, тоо хэмжээ хүчин чадал	Төрөл (бараа ажил, зөвлөх үйлчилгээ зөвлөхөөс бусад үйлчилгээ)	Санхүүжилтийн эх үүсвэр	Төсөвт өртөг (мян. төг)	Тухайн онд санхүүжих дүн (мян.төг)	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, арга	Тендер зарлах огноо	Гэрээ байгуулах эрх олгох огноо	Тайлбар, тодруулга
		Төсвийн хөрөнгө оруулалт								
1	ХА-01	Байрны түрээс	Зөвлөхөөс бусад үйлчилгээ	Улсын төсөв	431,100.01	431,100.01	Шууд гэрээ	1/1/2024	12/31/2024	ЭМДЕГ болон НДЕГ-тай 3-лсан гэрээ байгуулсан.
2	ХА-02	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	Бараа	Улсын төсөв	119,394.66	41,394.66 39,000.00 39,000.00	ХА ХА ХА	4/10/2024 4/10/2024 4/10/2024	6/10/2024 6/10/2024 6/10/2024	Багаж, тоног төхөөрөмж НРРС-ийн бодис, урвалж Ерөнхий химийн бодис, урвалж уусгагч
3	ХА-03	Хэмжилтийн тоног төхөөрөмжийн баталгаажуулалт	Үйлчилгээ	Улсын төсөв	80,000.00	80,000.00	ХА	10/11/2024	10/20/2024	Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх, хэмжлийн тоног төхөөрөмжийг олон улсын лабораторид баталгаажуулалт хийлгэх
4	ХА-04	Атом шингээлтийн спектрфотометр /AAS-7800 иж бүрдлийн хамт/	Бараа	Улсын төсөв	450,000.00	450,000.00	НТШ	4/25/2024	5/25/2024	ЭШЛ-ийн багаж

5	ХА-05	Ложистикийн үйлчилгээ авах	Үйлчилгээ	Улсын төсөв	97,277.19	97,277.19	ХА	10/29/2024	11/4/2024	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.5 дахь заалтаар
6	ХА-06	Эмийн хадгалалт, ложистикийн үйлчилгээ	Үйлчилгээ	Улсын төсөв	357,870.55	357,870.55	ХА	11/22/2024	12/20/2024	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.5 дахь заалтаар
	НИЙТ ДҮН				1,535,642.41					